



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2017 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 47

Номгон

Ашигт малтмалын ашиглалтын тусгай  
зөвшөөрлийг цуцлуулах санал уламжлах тухай

Баянхонгор аймгийн Заг сумын Баянбулаг I багийн нутаг Их булагийн эхэнд ашигт малтмалын ашиглалтын MV-012197 тусгай зөвшөөрөлтэй “Централ-Эшиа майнинг” ХХК-ний үйл ажиллагаа нь ундны усны эх үүсвэр Загийн голын ай сав, булаг шандны эх түүх дурсгалын булш, хирэгсүүрүүд, хадны сүг зураг, малын бэлчээр, малчдын өвөлжөө, хаваржаа сүйдэж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчих аюул бий болоод байгаа талаар Заг сумын иргэдээс удаа дараа өргөдөл, гомдол ирсээр байна.

Аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 29–ний өдрийн А/281 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэг Их булаг хэмээх газарт 21 булаг байдгаас 20 булаг нь тухайн талбайн гадна талд байгаа бөгөөд Ханангийн булаг нэртэй 1 булаг нь лицензийн талбайд давхцалтай байгааг тогтоосон байна.

Загийн гол нь Заг сумын төвийн хүн амын усан хангамжийн эх үүсвэр бөгөөд Их булаг нь Загийн голын урсац бүрэлдэх хэсгийн нэгж бөгөөд ихэнх тэжээл нь газрын доорх усаар уг голд нийлдэг байна. Их булаг нь Баянбулаг багийн малчдын отрын гол нутаг бөгөөд Заг сумын малчдын хувьд түшиц нутаг байна.

Тус компаний эзэмшиж буй лицензийн талбай нь Баянхонгор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2012 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 16/2 тоот “Аймгийн тусгай хамгаалалттай газрын хилийн цэс шинэчлэн тогтоох тухай” тогтоолоор баталсан аймгийн тусгай хамгаалалттай газарт хамрагдаж байна.

Заг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс 2017 оны 03 дугаар сарын 02-ны өдөр “Сумын нутаг дэвсгэр Их булагт ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулахгүй байх иргэдийн саналыг дэмжиж, хүсэлт уламжлах тухай” 11 дүгээр тогтоол, 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн “Их булагт хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулахгүй байх талаар хүсэлт уламжлах болон сумын зарим газар нутгийн орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар бэлтгэл ажил хангах тухай” 17 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 29–ний өдрийн А/281 тоот захирамжаар

D;2017-togtool2017

116173

томилогдсон ажлын хэсгийн дүгнэлтийг ТЭМДЭГЛЭЭД Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 62 дугаар зүйлийн 62.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.1.7, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дах заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн “Аймгийн тусгай хамгааллалттай газрын хилийн цэс шинэчлэн тогтоох тухай” 16/2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Заг сумын Баянбулаг 1 дүгээр багийн нутаг Их булагт үйл ажиллагаа явуулах “Централ-Эшиа майнинг” ХХК-ний ашигт малтмалын ашиглалтын MV-12197 тусгай зөвшөөрлийг цуцлуулах саналыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхай хүнд үйлдвэрийн яаманд уламжилсугай.

2. Централ-Эшиа майнинг ХХК-ний үйл ажиллагааг зогсоож, ашигт малтмалын ашиглалтын MV-12197 тусгай зөвшөөрлийг цуцлуулах талаар холбогдох байгууллагад хандаж, тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР